**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 15 өдөр Дугаар А/08 Хэрлэн сум

Автозамын түр чиглэл
батлах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 20 дугаар зүйлийн 20.1.21, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, 12.1.8, 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Монголросцветмент ТӨҮГ-ын харьяа Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших Хөх-Дэлхийн уурхайгаас олборлосон хүдрийг “Бор-Өндөр” уулын баяжуулах үйлдвэр хүртэл Хэнтий аймгийн нутгаар тээвэрлэлт хийх 7 км авто замын түр чиглэлийн солбицлын цэгийг нэгдүгээр хавсралтаар, зураглалыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Батлагдсан авто замын түр чиглэлийн дагуу замын арчлалт хамгаалалтыг тогтмол хийж, хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган, уртын тээврийн жолооч нарын тээвэрлэлтийг хууль, дүрэм, журмын хүрээнд сайтар зохион байгуулж, ачаа тээвэрлэх үйл ажиллагааг гүйцэтгэн ажиллахыг “Монголросцветмент” ТӨҮГ-т үүрэг болгосугай.

3.Батлагдсан түр чиглэлийн дагуу бүтээгдэхүүн тээвэрлэлтийн замын хөдөлгөөний зохион байгуулалтад хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Э.Жавхлантөгс), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Мөнх-Эрдэнэ), Хэнтий аймгийн Авто тээврийн төв (Ц.Бат-Эрдэнэ) нарт батлагдсан чиглэлийн зураглалд оруулж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Б.Сүнгээ)-д тус тус даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\ Захирамж-2024

Аймгийн Засаг даргын 2024
оны 01 дүгээр сарын 15-ны
А/08 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

# Авто замын түр чиглэлийн солбицол

| Цэг № | WGC-84 | |
|---|---|---|
| | Өргөрөг | Уртраг |
| 1 | 46°14'57.16"N | 109°25'6.70"E |
| 2 | 46°14'34.98"N | 109°25'9.11"E |
| 3 | 46°14'9.82"N | 109°24'54.28"E |
| 4 | 46°13'21.46"N | 109°24'42.74"E |
| 5 | 46°12'54.55"N | 109°24'7.06"E |
| 6 | 46°12'36.67"N | 109°23'54.91"E |
| 7 | 46°12'22.09"N | 109°23'32.53"E |
| 8 | 46°11'49.13"N | 109°22'51.25"E |
| 9 | 46°11'29.13"N | 109°22'47.60"E |




Боловсруулсан: Ерөнхий маркшейдер..............Э.Цолмон Авто тээврийн цехийн дарга..............Б.Идэрбаяр